



ШҮҮХИЙН ҮЙЛ АЖИЛЛАГААНД ХИЙМЭЛ ОЮУН АШИГЛАХ ЭРХ ЗҮЙН ЗОХИЦУУЛАЛТ, ЗАРЧМУУДЫН ХАРЬЦУУЛСАН ТОЙМ СУДАЛГАА (2015–2025)

A COMPARATIVE REVIEW STUDY OF THE LEGAL REGULATION AND PRINCIPLES GOVERNING THE USE OF ARTIFICIAL INTELLIGENCE IN JUDICIAL ACTIVITIES (2015–2025)

Содномцэрэнгийн Заяадэлгэр¹

Shihihutug University, E-mail: Szayadelger@supremecourt.mn

ӨГҮҮЛЛИЙН ТУХАЙ

Түлхүүр үгс:

Artificial intelligence; use of artificial intelligence in the judiciary; legal regulation of artificial intelligence; comparative study of artificial intelligence; legal principles

Нийтлэлийн түүх:

Хүлээн авсан: 2026, 03 сар
Шинэчилсэн: 2023, 03 сар
Хүлээн зөвшөөрсөн:
2023, 04 сар

Keywords:

Хиймэл оюун, Шүүхэд хиймэл оюун ашиглах, Хиймэл оюуны эрх зүйн зохицуулалт, Хиймэл оюуны харьцуулсан судалгаа, эрх зүйн зарчим

Article history:

Received Dec, 2024
Revised Feb, 2025
Accepted Mar, 2025

ХУРААНГУЙ

Олон улсад хувийн хэвшилээс гадна төрийн байгууллагууд үйл ажиллагаандаа хиймэл оюун нэвтрүүлж зардал хэмнэх, түргэвчлэх, үр нөлөөгөө дээшлүүлэх арга хэмжээ авч байна. Шүүхүүдийн хувьд мөн адил тодорхой хэмжээнд хиймэл оюун нэвтрүүлж байгаа ч хүний эрхийн зөрчилтэй холбоотой нарийн ээдрээтэй, үр дагавар ихтэй ийм ажиллагаанд хиймэл оюун ашиглах эрх зүйн орчин чухал. Олон улсад энэ талаар ялгаатай зохицуулалт, номлолыг баримталж байгааг уг судалгаанд авч үзлээ. Ингэхдээ олон улсын ба бус нутгийн зохицуулалтын чиг хандлага, үндэсний эрх зүйн зохицуулалт ба туршилага гэсэн түвшинд хувааж Европын холбоо, АНУ, Герман, Япон, Сингапур зэрэг улсын эрх зүйн тоймыг шинжлэв.

Internationally, both public authorities and private-sector actors are increasingly integrating artificial intelligence into their operations as a means of reducing costs, accelerating processes, and enhancing overall effectiveness. Courts are no exception and have likewise begun to introduce artificial intelligence to a certain extent. However, given the complexity, sensitivity, and potentially far-reaching consequences of judicial activities—particularly those involving human rights—an appropriate legal and regulatory framework governing the use of artificial intelligence is of critical importance. This study examines the diverse regulatory approaches and doctrinal positions adopted at the international level. To this end, the analysis is structured across two dimensions: trends in international and regional regulation, and national legal frameworks and practices. Within this framework, the study provides a comparative legal overview of selected jurisdictions, including the European Union, the United States, Germany, Japan, and Singapore

¹Монгол Улсын дээд шүүхийн Тамгын газрын дарга, Шихихутуг их сургуулийн докторант

Энэ өгүүлэл CC BY-NC лицензийн дагуу нээлттэй хандалтын эрхтэй.



1. Танилцуулга

Энэхүү судалгаа нь хууль хэрэглэх тогтолцооны онолын үндэс, бүтэц, үйл ажиллагааны механизмыг тодорхойлохын зэрэгцээ Үндсэн хуулийн хэрэглээний онцлог, түүний хууль хэрэглэх тогтолцоонд эзлэх байр суурийг шинжлэхэд чиглэсэн болно. Судалгааны зорилго, зорилтыг хэрэгжүүлэхийн тулд эрх зүйн шинжлэх ухаанд түгээмэл хэрэглэгддэг онолын болон эмпирик судалгааны аргуудыг хослуулан ашиглаж, хууль хэрэглэх тогтолцооны интеграл загварыг боловсруулах арга зүйн үндсийг бүрдүүлэхэд чиглэсэн.

2. Арга зүй

Энэхүү судалгаанд хууль хэрэглэх тогтолцоог норматив, институцийн, тайлбарлах болон үнэт зүйлсийн хэмжээсүүдийн харилцан хамаарал бүхий интеграл систем гэж үзэх онолын хандлагад тулгуурлан, харьцуулсан эрх зүйн, системийн шинжилгээний, тайлбар зүйн (hermeneutic) болон кейс судалгааны аргуудыг хослуулан ашиглав.

3. Судалгааны үр дүн

Олон улсын болон бүс нутгийн зохицуулалтын хандлага

Сүүлийн арван жилийн хугацаанд шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюуныг идэвхтэй ашиглах болсон ба үүнийг дагаад олон улсын болон бүс нутгийн түвшинд эрх зүйн зарчим бүхий удирдамжууд батлагдсан. Тухайлбал, Европын зөвлөл 2018 онд Шүүхийн тогтолцоонд хиймэл оюун ухаан ашиглах ёс зүйн дүрмийг баталсан нь хиймэл оюуны талаарх дэлхийн анхны баримт бичиг болсон юм. Тус дүрмийн хүрээнд үндсэн эрхийг хүндэтгэх, ялгаварлан гадуурхалтаас ангид байх, мэдээллийн чанар ба аюулгүй байдлыг хангах, ил тод, шударга, төвийг сахисан байх, хэрэглэгчийн хяналтад байх зэрэг таван үндсэн зарчмыг тодорхойлсон байдаг. Эдгээр нь Европын Хүний эрхийн конвенцын хүрээнд баталгаажсан эрхүүдтэй уялдаатай бөгөөд аливаа хиймэл оюун ухааны хэрэгсэл нь нийтийн ашиг сонирхолд үйлчилж, хувь хүний эрхийг зөрчихгүй байх ёстойг онцолсон байна.²

Европын Холбооны зүгээс энэ хүрээнд эрх зүйн зохицуулалтыг хөгжүүлэхэд ихээхэн анхаарч, 2021 оноос хэлэлцэн 2024 онд Европын Холбооны Хиймэл оюуны тухай хууль (AI Act)³ баталсан. Уг хууль нь хиймэл оюун ухааны хэрэглээг эрсдэлийн

²CEPEJ European Ethical Charter on the use of artificial intelligence (AI) in judicial systems and their environment - European Commission for the Efficiency of Justice (CEPEJ), <https://www.coe.int/en/web/cepej/cepej-european-ethical-charter-on-the-use-of-artificial-intelligence-ai-in-judicial-systems-and-their-environment>

³ EU, AI Act, <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:32024R1689>

түвшнээр нь ангилж, шүүх эрх мэдэл, ардчилсан үйл явцтай холбоотой хиймэл оюуны системүүдийг “өндөр эрсдэлтэй” ангилалд багтаасан. Тус хуульд шүүхийн хэрэглэх хиймэл оюун ухааны системүүд нь хүний эрх, тухайлбал шударга шүүхээр шүүлгэх эрхэд сөргөөр нөлөөлөх өндөр магадлалтай тул онцгой хяналт, үнэлгээнд хамрагдах ёстой гэжээ. Түүнчлэн, шүүгчийн шийдвэр гаргах бүрэн эрхийг ямар ч нөхцөлд хиймэл оюун ухаан орлож болохгүй, эцсийн шийдвэрийг хүн гаргах зарчмыг тодорхой зааж өгсөн байна.⁴ Энэ нь өмнө дурдсан Европын зөвлөл (СЕРЕJ)-ийн “хэрэглэгчийн хяналтад байх” буюу “шүүгч-хүний оролцоог хангах” зарчмыг хуульчлан бататгасан алхам юм. Мөн Европын Холбооны 2016 оны Хувийн мэдээллийг хамгаалах ерөнхий журам (GDPR)⁵-ын 22 дугаар зүйлд иргэд автомат боловсруулалт дээр үндэслэн гаргасан, хууль эрх зүйн үр дагавар бүхий шийдвэрт захирагдахгүй байх эрхтэй гэж заасан. 2023 онд Европын Холбооны Шүүх (СJEU) уг заалтыг албан ёсоор тайлбарлахдаа, ямар ч тохиолдолд дан алгоритмд тулгуурлан хувь хүний эрх, үүрэгт нөлөөлөх шийдвэрийг гаргаж болохгүйг онцолжээ.

OECD (ЭЗХАХБ) нь 2019 оны Хиймэл оюуны зарчмаараа техник технологийг хүний эрх, хууль дээдлэх ёсонд нийцүүлэн хэрэглэхийг уриалж, ил тод байдал, хариуцлага, ялгаварлалгүй байдал зэрэг нийтлэг үнэт зүйлийг тунхагласан. Үүний зэрэгцээ НҮБ-ын дэргэдэх зарим сүлжээ, жишээ нь Глобал шүүхийн шударга байдлын сүлжээ зэргээр дамжуулан шүүгчийн ёс зүй, шударга шүүхийн зарчим дахь хиймэл оюун ухааны нөлөөллийг хэлэлцэх болсон. Тухайлбал, Америкийн Хуульчдын Холбоо (АВА)-ны Шүүхийн ёс зүйн хороо 2025 онд шүүгч нарт зориулсан хиймэл оюун ухаан ашиглах удирдамж гаргаж, шүүхийн шийдвэр гаргалтын суурь нь хүний оюун тул хиймэл оюуныг зөвхөн туслах хэрэгсэл байдлаар ашиглаж, хүний оюуныг орлох түвшинд хүргэж үл болох тухай онцлон зөвлөсөн байдаг.⁶ Ингээд олон улсын түвшинд “хүний хяналттай, хариуцлагатай хиймэл оюун ухаан”, “ил тод ба тайлагналтай алгоритм”, “ялгаварлан гадуурхалтаас ангид байдал”, “мэдээллийн нууцлал ба аюулгүй байдал” зэрэг суурь зарчмууд хангалттай тодорхойлогджээ.

Үндэсний эрх зүйн зохицуулалт ба туршлага

Улс орнууд болон бүс нутгийн хамтын ажиллагааны байгууллагууд сүүлийн 10 жилд хиймэл оюуныг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлж, эрх зүйн орчноо харилцан адилгүй хөгжүүлсэн байна. Эдгээрээс зарим гол жишээг онцлон авч үзье.

Америкийн Нэгдсэн Улс (АНУ)

Америкийн Нэгдсэн Улсын шүүхийн холбооны түвшинд хиймэл оюун ухаан ашиглах талаар цогц хууль, дүрэм хараахан батлагдаагүй ч практик хэрэгцээнээс үүдэн

⁴ Recital 61 - High-risk AI systems in the administration of justice - AI Act <https://ai-act-law.eu/recital/61/>

⁵ EU, General Data Protection Regulation, <https://eur-lex.europa.eu/eli/reg/2016/679/oj/eng>

⁶ Guidelines for Judicial Officers: Responsible Use of Artificial Intelligence, <https://www.americanbar.org/groups/judicial/resources/judges-journal/2025-spring/guidelines-judicial-officers-responsible-use-artificial-intelligence/>

шүүхийн байгууллагууд өөрсдөө зарим чиглэл, бодлогыг тодорхойлоод эхэлсэн. Тухайлбал, шүүн таслах ажиллагаанд гэмт хэрэг дахин үйлдэх эрсдэлийг тооцдог алгоритм (risk assessment)-ыг ашиглах болсон нь олон маргаан дагуулсан. Жишээлбэл, 2016 онд Висконсин мужийн Дээд шүүх State v. Loomis хэргийг шийдвэрлэсэн ба уг хэргийн хүрээнд ялтанд оноох ялын хэмжээг тогтоохдоо COMPAS компанийн боловсруулсан алгоритмын үнэлгээг ашигласан нь хэргийн оролцогчдын шударга шүүхээр шүүлгэх эрхэд нөлөөлөх эсэх талаар хэлэлцэгдсэн. Тухайн алгоритмын нууц цөм, аргачлалыг шүүгч, эсвэл ялтанд мэдээлээгүй ч энэ нь Үндсэн хуулийн шударга ёсны зарчмыг ноцтой зөрчөөгүй гэж шүүх үзэн хэрэглэхийг зөвшөөрсөн. Харин хэрэглэхдээ хавсаргасан хэд хэдэн болзол, сануулгыг дагаж мөрдөхийг даалгажээ. Тухайлбал, зөвхөн алгоритмын үнэлгээнд тулгуурлан шийтгэлийн хэмжээг тогтоож болохгүй, уг үнэлгээ нь ял шийтгэлийг оновчлоход туслах мэдээлэл төдий болохоос хүнээс давсан шийдвэр гаргах ёсгүйг онцолсон. Мөн уг программыг боловсруулахад ашигласан өгөгдөл, аргачлал нь нээлттэй бус (нууц) тул шүүгчид зориулан “хэрэглэхдээ болгоомжтой байх талаар бичгээр анхааруулга хүргүүлж, түүний дотор энэ үнэлгээ нь ганцхан магадлал тооцсон дүн тул тухайн хэрэгт заавал нийцнэ гэсэн баталгаа байхгүй гэдгийг ойлгуулах шаардлагатай” гэж заасан байна.⁷ Энэ нь шүүхийн практикт гарч буй “хүний хяналттай хэрэглээ”-ний зарчмын илэрхийлэл юм. АНУ-ын зарим мужид ийм төрлийн алгоритмын хэрэглээнд хязгаарлалт тавих, жишээлбэл шинжээчийн дүгнэлттэй адил ажиллагаа явуулах, эсвэл мэдээллийн тэгш хүртээмжийг хангахтай холбоотой хууль, журам батлах оролдлогууд хийгдэж байна.

Шүүхийн захиргааны байгууллагын түвшинд, АНУ-ын Шүүхүүдийн бага хурал (Judicial Conference) болон Үндэсний шүүхийн төвүүдээс хиймэл оюуныг хэрхэн зөв ашиглах талаар зөөлөн хүчний удирдамж гаргаж байна. 2024 онд Үндэсний мужийн шүүхийн төв (NCSC) болон Thomson Reuters-ийн хамтарсан ажлын хэсэг шүүхэд Generative AI хэрэглэх зарчмыг гаргаж, эрсдэлийн түвшнээс нь хамааруулан хүний оролцоог ялгаатай тогтоох саналыг дэвшүүлсэн. Жишээ нь, бичиг баримт боловсруулах зэрэг эрсдэл багатай ашиглалтад хяналт тавих “human-on-the-loop” буюу зайнаас хянах хэлбэрийг, харин шүүхийн шийдвэрт нөлөөлөх эрсдэл өндөртэй хэрэглээнд заавал “human-in-the-loop” буюу шууд хүний оролцоотой хяналт тавьж, эцэст нь хүн өөрөө шийдвэрлэх зарчмыг хангахыг зөвлөсөн.⁸ Мөн ийм өндөр эрсдэлтэй хэрэглээг тодорхойлолтоор нь хязгаарлахыг санал болгож, ял шийтгэл, хорих, гэр бүлийн болон орон байртай холбоотой шийдвэрийг бүрэн автоматжуулж хэрхэвч болохгүй гэж онцолсон байна.⁹ 2023-2025 оны хооронд АНУ-д Шүүхийн танхимд иргэд, өмгөөлөгчид хиймэл оюун ухаан ашиглахад тавих шаардлага, журам боловсруулах хандлага бий болжээ. 2023 онд Нью-Йорк хотод нэгэн өмгөөлөгч шүүхийн мэдүүлэг, бичиг баримтаа ChatGPT ашиглан боловсруулсан нь тухайн хиймэл оюун ухаан зохиомол, ор

⁷ State v. Loomis - Harvard Law Review, <https://harvardlawreview.org/print/vol-130/state-v-loomis/>

⁸ Principles & practices for AI use in courts | National Center for State Courts, <https://www.ncsc.org/resources-courts/principles-practices-ai-use-courts>

⁹ National Center for State Courts, *supra* note 7

үндэслэлгүй шүүхийн жишиг “зохиож” оруулсан ноцтой асуудал үүсгэж, шүүхээс сахилгын шийтгэл оногдуулсан.¹⁰ Уг хэргийг хянан шийдвэрлэсэн шүүгч П.Кастел шийдвэртээ өмгөөлөгчид технологийн тусламж авах нь хориотой зүйл биш боловч мэргэжлийн ёс зүйн үүргийн дагуу аливаа баримт, эшлэлээ нягтлан шалгах “шаардлагатай шүүлтүүрийн үүрэг” өөрсдөд нь байгааг сануулсан. Үүнтэй уялдан АНУ-ын хэд хэдэн шүүх 2023 онд хиймэл оюун ухаан ашигласан өмгөөлөгч, хуулийн фирмүүдийг тэр тухайгаа мэдэгдэх, ашигласан программыг нэрлэх, нууцлал алдагдаагүйг баталгаажуулах шаардлагыг журамлаж эхэлсэн байдаг. Тухайлбал, АНУ-ын Олон улсын худалдааны шүүхийн шүүгч С.Вэйдэн захирамждаа “хэрэв талууд бичиг баримтдаа ChatGPT зэрэг хиймэл оюун ухаан ашиглавал аль хэсэгт, ямар программууд ашигласнаа мэдэгдэх, мөн уг технологи нь нууцлалтай мэдээллийг алдагдуулаагүйг гэрчлэх үүрэгтэй” гэжээ.¹¹ Эдгээр нь шүүхийн болон хуульчдын ил тод байдал, хяналт, мэргэжлийн хариуцлагыг хангах гол зарчим гэдэг утгаараа АНУ-д төлөвшсөн практик гэж хэлж болно.

Европын Холбоо ба Герман

Европын Холбооны хүрээнд дээр дурдсан AI Акт-ийн зохицуулалт өргөн хүрээтэй шинэчлэл авчрах төлөвтэй байна. Үүний зэрэгцээ гишүүн улсууд тус бүртээ шүүхэд хиймэл оюуныг хэрэглэх нөхцөл, хязгаарыг өөр өөрөөр тусган зохицуулж байна. Герман Улсын хувьд одоогоор хиймэл оюун ухаанд зориулсан тусдаа хууль тогтоомж батлаагүй, харин холбогдох нийтлэг хууль, дүрмийг мөрдөж байна. Тухайлбал, хувь хүний мэдээллийг хамгаалах, автомат шийдвэр гаргалтаас татгалзах талаар ЕХ-ны GDPR-ийг дагаж мөрдөх ба ингэснээр шүүхийн шийдвэр гаргалтад дан автомат алгоритм ашиглахыг хориглох зарчим үйлчилнэ. Герман нь мөн ЕХ-ны шинээр батлах хиймэл оюун ухааны хуульд нийцүүлэн үндэсний хуульдаа өөрчлөлт оруулах бэлтгэл хангаж байгаа ба тусгайлан өөрийн улсаа бүхнийг хамарсан хиймэл оюуны хууль гаргахгүй, харин ЕХ-ны эрх зүйн хүрээнд үйл ажиллагаагаа явуулна гэж мэдэгдсэн.

Үүнээс гадна Герман Улс шүүхийн практикт хиймэл оюун ухааны хэрэгслүүдийг нэвтрүүлэх, турших чиглэлээр тэргүүлж байна.¹² Тухайлбал, 2026 он гэхэд улсын хэмжээнд бүх шүүх хэргийг цахим материал (electronic case files) хэлбэрээр хүлээн авч, боловсруулахыг хуульчлан үүрэг болгосон нь шүүхийн ажил илүү дижитал орчинд явагдаж, хиймэл оюун ухааны туслах системүүдийг хэрэглэх суурь болжээ. Жишээлбэл, Германы Баден-Вюртемберг мужийн шүүхүүдэд OLGA хэмээх хиймэл оюун ухаанд суурилсан алгоритм, туслах системийг ашиглаж эхэлсэн ба энэ нь олон мянган иргэний хэрэг, нэхэмжлэлийг агуулгаар нь автоматаар ангилан бүлэглэх, холбогдох өгөгдлийг цуглуулан шүүх бүрэлдэхүүнд хурдан шуурхай танилцуулах зорилготой юм. OLGA

¹⁰New York lawyers sanctioned for using fake ChatGPT cases in legal brief | Reuters, <https://www.reuters.com/legal/new-york-lawyers-sanctioned-using-fake-chatgpt-cases-legal-brief-2023-06-22/>

¹¹ Reuters, *supra* note 11

¹² Judicial systems are turning to AI to help manage vast quantities of data and expedite case resolution | IBM, <https://www.ibm.com/case-studies/blog/judicial-systems-are-turning-to-ai-to-help-manage-its-vast-quantities-of-data-and-expedite-case-resolution>

систем нь хэргийн материалуудаас голлох мэдээллийг шүүгчид болон шүүхийн ажилтнуудад ялган танилцуулснаар ижил төстэй нэхэмжлэл бүхий хэргүүдэд давтагддаг, их ачаалал шаардсан ажлуудыг мэдэгдэхүйц бууруулж, улмаар шүүгчдэд хэргийн илүү төвөгтэй асуудлуудад анхаарлаа төвлөрүүлэх боломжийг олгодог. Мөн Франкфурт хотын шүүхэд “Frauke” нэртэй хиймэл оюун ухааны программыг зорчигч болон агаарын тээврийн маргаантай хэргүүдэд туршсан. Энэ нь нэхэмжлэлийн материалуудаас нислэгийн дугаар, сааталтын хугацаа зэрэг хэрэгт хамаарах өгөгдлийг автоматаар түүвэрлэж, шүүгчийн шийдвэр (жишээлбэл нөхөн төлбөр олгох эсэх) гарсны дараа уг шийдвэрийн үндэслэл бүхий шийтгэврийн төслийг урьдчилан бэлтгэхэд тусалсан. Ингэснээр агаарын тээврийн олон мянган ижил төстэй маргааны шийтгэвэр гаргах ажиллагаанд зарцуулах хугацаа үлэмж багассан. Германчууд эдгээр технологийг нэвтрүүлэхдээ ил тод, үр дүн нь тайлагнагдахуйц байх, хүний хяналтад ажиллах, өгөгдлийн аюулгүй байдал, нууцлалыг хангах гэсэн зарчмыг баримталж буйг төслийн гүйцэтгэгч IBM-ийн тайланд дурджээ.¹³ Нөгөөтээгүүр, Герман Улсад хиймэл оюун ухааны шийдлийг шүүхийн шийдвэр гаргалтад шууд оролцуулахыг хуулиар зөвшөөрөөгүй тул дээрх OLGA, Frauke зэрэг нь туслах, дэмжих үүрэгтэй, харин шүүгч эцсийн шийдвэрээ гаргахдаа эдгээрийн гаргасан саналыг заавал харгалзах албагүй, өөрийн шүүн тунгаах бүрэн эрхээ хадгалдаг байна.

Япон

Япон Улс хиймэл оюун ухааны эрх зүйн зохицуулалтаараа *soft law* буюу уян хатан хандлагыг баримталж байна. 2023 онд Японы парламент Хиймэл оюуныг дэмжих тухай хууль (AI Promotion Act) баталсан нь түүний хөгжлийг дэмжих, инновацыг хөгжүүлэх зорилготой чухал алхам болсон. Тус акт нь журам, стандартыг хатуу тогтоосон шууд хориглосон гэхээс илүү удирдамж, зарчмын шинжтэй бөгөөд хиймэл оюун ухааны зохистой хэрэглээг төр, хувийн хэвшилд төлөвшүүлэх зарчмыг тунхагласан. Тухайлбал, хариуцлагатай инновац, хүн төвтэй хөгжил зэрэг ерөнхий чиглэлийг гаргаж, цаашид Японы Засгийн газар энэ хүрээнд тодорхой стандарт, аргачлал боловсруулах үүрэг хүлээсэн байна. Япон Улсад одоогоор хиймэл оюуныг шүүн таслах ажиллагаанд ашиглахыг зөвшөөрсөн, эсвэл хориглосон тусгай акт батлагдаагүй. Гэсэн ч шүүхийн практикт хиймэл оюуныг дэмжих туршилтууд хийгдэж эхэлсэн. 2024 оны байдлаар Японы шүүх, прокурорын байгууллагууд зарим нотлох баримт, видео бичлэгийг автоматжуулан шүүх хуралдаанд бэлтгэх, зарим төрлийн шийдвэрийн төслийг боловсруулахад туслах программ ашиглаж буй талаар мэдээлэл бий. Японы Шүүхийн ерөнхий зөвлөл, Хууль зүйн яам хамтран шүүхэд хиймэл оюун ухаан хэрэглэх ёс зүй, зарчмын талаар судалгаа, зөвлөмж боловсруулж эхэлсэн. Түүнчлэн, шүүгчийг орлох хиймэл оюун ухааны хувьд болгоомжтой хандаж, шүүхээр шүүгдэх эрхийг (Японы Үндсэн хуулиар баталгаажсан) зөрчихгүйн тулд аливаа хиймэл оюун ухаан нь шүүгчийн

¹³ IBM, *supra* note 11

туслах хэрэгсэл төдий байхаас хэтрэхгүй байх ёстой гэжээ.¹⁴ 2023 онд Японы Дээд шүүхийн дэргэд шүүгч, хуульчдын судалгааны бүлэг байгуулагдаж, 2025 онд “Шүүхийн хиймэл оюун ухаан ашиглах удирдамж” нэртэй зөвлөмжийг гаргасан нь шүүгч, шүүхийн албан хаагчид хиймэл оюуны хэрэгслийг хэрхэн аюулгүй, хянуур ашиглах талаар практик зөвлөгөө өгсөн анхны баримт бичиг болжээ.¹⁵ Уг удирдамжид шүүхэд хиймэл оюун ухаан хэрэглэхдээ үндсэн эрхийг хамгаалах, тайлбарлагдахуйц байдлыг хангах, хариуцлагын зааг, хүний оролцоог тодорхой байлгах гэсэн зарчмыг тулгуур болгож, шүүгч бүр технологийн үр дагаврыг ухамсарлах чадавхаа сайжруулах шаардлагатайг цохон тэмдэглэсэн байна.¹⁶ Нэгтгэн дүгнэвэл, Япон Улс шүүхийн хиймэл оюун ухааны талбарт хуульчийн санаачилга, сайн дурын ёс зүйн практикт илүү тулгуурлаж, албадмал норм тогтоохоос зайлсхийсэн хандлагатай байна.

Сингапур болон Азийн бусад улс орнууд

Сингапур Улс шүүхийн үйлчилгээг шинэчлэх, дижиталчлах чиглэлээр Ази тивдээ тэргүүлэгчдийн нэг юм. Сингапурын шүүхүүд 2020 оноос хойш хэд хэдэн хиймэл оюунд суурилсан туршилтыг эхлүүлсэн. Тухайлбал, иргэд шүүхэд өөрийгөө төлөөлөх (self-represented litigants) тохиолдолд тэдэнд хууль зүйн мэдээлэл, зөвлөгөө өгөх “чатбот” хэлбэрийн туслах системийг generative AI технологиор хөгжүүлж туршжээ. Мөн зарим шүүх хуралдааны материалыг шүүгчид уншихаас өмнө автоматаар нэгтгэн дүгнэх системийг туршин хэрэгжүүлж, энэ нь шүүгч нарт цаг хэмнэх, гол асуудлыг шүүх хуралдаанаас өмнө ойлгоход тусалж байна.¹⁷ Сингапурын хууль эрх зүйн орчин технологийн шинэчлэлийг дэмжиж ирсэн ба 2019 онд тус улсын Хувийн мэдээлэл хамгааллын хорооноос гаргасан “Хиймэл оюун ухааны засаглалын загвар хүрээ” нь төр, хувийн хэвшлийн байгууллагууд хиймэл оюун ухаан хэрэглэхэд баримтлах зарчим, шалгуурыг тодорхойлсон байдаг. Энэ хүрээнд ил тод байх, хариуцлага тооцох бүтэцтэй байх, шударга байдлыг хангах, хэрэглэгчдийг оролцуулж турших зэрэг зарчмыг дурдсан нь шүүхийн үйл ажиллагаанд ч чухал хэмээн үзэж, шүүхийн захиргаа эдгээрийг мөрдөхөө илэрхийлсэн. Сингапур Улсад шүүхийн шийдвэрийг автоматаар гаргах талаар ямар нэг туршилт хийгдээгүй, харин шүүхийн захиргааны ажлыг сайжруулах, иргэдэд мэдээлэл хүргэх чиглэлээр хиймэл оюуныг түлхүү ашиглаж байна. Тухайлбал, цахим шүүх хуралдааны үед оролцогчдын өгсөн мэдээллийг бодит цаг хугацаанд нь анализ хийж, хуралдааны дэг алдагдуулахгүйгээр холбогдох хууль, прецедент шийдвэрийг шүүгчийн дэлгэцэд санал болгодог системийг Сингапур туршиж байгаа гэх мэдээлэл бий. Үүнийг ашигласнаар шүүгч хэрэг хэлэлцэх үедээ шууд шаардлагатай хуулийн зохицуулалт, өмнөх шийдвэрүүдийг харах боломжтой болж, шийдвэр гаргах хугацаа

¹⁴ *AI Judges in Courts of the Future and the Right to a Fair Trial in the ECHR by Vytautas Mizaras, Yogesh K. Dwivedi, Brian D. Earp, Mark Fenwick, Paul Jurcys, Souichirou Kozuka, Sebastian Porsdam Mann : SSRN, https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=5189606*

¹⁵ *How Asia Pacific region courts are managing AI adoption - Thomson Reuters Institute, <https://www.thomsonreuters.com/en-us/posts/ai-in-courts/asia-pacific-courts-ai/>*

¹⁶ *Thomson Reuters Institute, supra note 14*

¹⁷ *Thomson Reuters Institute, supra note 14*

багассан гэж урьдчилсан байдлаар үнэлсэн байдаг. Гэхдээ Сингапур Улсын зүгээс энэ бүхэнд ёс зүй, хариуцлагын асуудлыг нэн тэргүүнд тавьж, 2020 онд Хууль зүйн зөвлөлөөс “Хуулийн салбар дахь хиймэл оюун ухааны ёс зүйн зарчим”-ыг нийтэлж, хуульчид, прокурор, шүүгч нар хиймэл оюун ухаан хэрэглэхдээ мэргэшлийн ур чадварын хүрээндээ хяналт тавих, техникийн мэдлэгээ байнга дээшлүүлэх, алгоритмын гаргалгааг шууд хүлээж авахгүй байх үүрэгтэйг тунхаглажээ. Азийн бусад томоохон орнууд ч энэ чиглэлээр идэвхтэй арга хэмжээ авч байна.

БНСУ-д 2023 онд шүүхийн шинэтгэлийн хүрээнд тусгай хороо ажиллаж, 2024 оны 08 дугаар сард “Шүүхийн ажиллагаанд хиймэл оюун ухаан хэрэглэх зөвлөмж” баталжээ. Тус зөвлөмжид үндсэн эрхийг хамгаалах, хариуцлага, ил тод байдлыг хангах зарчмыг онцгойлон дурдсан бөгөөд үүний дараа Өмнөд Солонгосын шүүгч нарын холбооноос 2025 оны 02 дугаар сард шүүгч болон хэргийн оролцогчдын хиймэл оюун ухаан хэрэглэх аюулгүй байдлын удирдамжийг мөн хэвлүүлсэн байна.

Австрали Улсын хувьд шүүхийн зүгээс шүүгч, хуульчдад хандсан баримт бичиг баталсан. Шинэ Өмнөд Уэльс мужийн Дээд шүүхээс 2023 онд гаргасан практикийн заавраар (Practice Note) хэргийн материалыг бүрдүүлэхдээ Generative AI ашиглах тохиолдолд нягт нямбай хандах, баталгаажуулахгүйгээр шүүхэд нотлох баримт болгон өгөхийг хориглосон.¹⁸ Энэ нь дээр өгүүлсэн АНУ-ын шүүхийн сануулгатай ижил, өөрөөр хэлбэл аль ч улсад хуульч, талууд ийнхүү технологийг ашиглахдаа хариуцлагаа умартаж болохгүйг харуулж байна.

БНХАУ “Smart Court” буюу “ухаалаг шүүх” хөтөлбөрийг бүх шатны шүүхдээ нэвтрүүлж, хиймэл оюун ухаан болон их өгөгдлийн технологийг шүүхийн үйл ажиллагааны бүхий л хүрээнд хэрэглэж буй хамгийн том жишээ юм. Хятадын шүүхүүд сая гаруй шийдвэрийн сан, хууль тогтоомж, шүүхийн практикийг нэг сүлжээнд холбосон мэдээллийн системтэй бөгөөд шүүгчид уг системийн автомат хуулийн хайлт, загварчлал, алдаа шалгах функцийг өдөр тутамдаа ашиглаж байна. Зарим цахим шүүхүүдэд хэрэг хэлэлцэх үеэр хиймэл оюунт “виртуал шүүгч” (холограм дүрс бүхий программ) оролцох туршилт ч хийгдэж, энгийн маргаануудыг электрон орчинд, хүн шүүх бүрэлдэхүүнгүйгээр шийдвэрлэх боломжийг судалсан мэдээлэл бий. Гэхдээ Хятадын Дээд шүүхээс 2019 онд гаргасан зааварт аливаа технологи нь шүүгчийн туслах хэрэгсэл байх бөгөөд шүүхийн эцсийн шийдвэрийг заавал хүн баталгаажуулж гаргана гэж зарласан байдаг. Өөрөөр хэлбэл, Хятадын хувьд маш өргөн хүрээнд автоматжуулалтыг нэвтрүүлж байгаа ч шүүгчийн хараат бус байдлыг хангах, технологийн алдаа гаргахаас сэргийлэх үүднээс хүний оролцооны зарчмыг хэвээр хадгалж байна. Ерөнхийдөө, Ази Номхон далайн бүсэд байрших ихэнх орнууд хиймэл оюуныг шүүхэд нэвтрүүлэхдээ болгоомжтой, үе шаттай, эхлээд туршилтын журмаар хэрэгжүүлэн, зэрэгцүүлэн ёс зүйн болон засаглалын хүрээг нь тодорхойлох замыг сонгож байна.¹⁹

¹⁸ Thomson Reuters Institute, *supra* note 14

¹⁹ Thomson Reuters Institute, *supra* note 14

Шүүгч, шүүх ба шүүхийн оролцогчдын үүрэг, хариуцлага

Шүүхийн ажиллагаанд хиймэл оюуныг нэвтрүүлэхтэй холбоотой эрх зүйн зарчмуудыг авч үзэхдээ зөвхөн хууль, дүрэм төдийгөөр бус, шүүх эрх мэдлийг хэрэгжүүлэгч шүүгч, шүүхийн байгууллага болон шүүхийн оролцогч талууд (өмгөөлөгч, прокурор, иргэд) хэрхэн хүлээн авч, хэрэгжүүлж буйгаар нь ангилан авч үзэх нь зүйтэй.

Шүүгчийн түвшинд, хиймэл оюун ухаан нь шийдвэр гаргагчийг орлож чадахгүй, харин чадваржуулах нэмэлт хэрэгсэл гэсэн байр суурь хүчтэй байна.²⁰ Дэлхийн олон орны шүүгчид хиймэл оюуныг ажилдаа ашиглах туршлага хуримтлуулж эхэлсэн ч уг технологид *хянуур хандах* нь шүүгчийн ёс зүйн салшгүй хэсэг хэвээр байна. АНУ, Канад, Европын зарим орны шүүгчид хамтран 2025 онд боловсруулсан “Шүүхэд хиймэл оюун ухаан ашиглах удирдамж”-д хиймэл оюуны боловсруулсан аливаа зөвлөмж, шинжилгээг шүүгчид заавал өөрийн шүүлтүүрээр нягталж, эцэст нь ухамсарт шийдвэрийг гаргах үүрэгтэйг онцолсон байдаг.²¹ Учир нь шүүхийн шийдвэр гаргалтын амин сүнс нь шударга ёсны үнэлэмж, хүний оюун ухаан байдаг тул хиймэл оюуныг үйл явцыг хурдасгах, мэдээллээр хангах зорилгоор ашиглах ёстой болохоос тухайн үнэлэмжийг орлож, хялбарчлах зорилгоор ашиглаж болохгүй гэж үздэг. Иймд, шүүгч бүр технологийн мэдлэгээ нэмэгдүүлж, алгоритмын ажиллах зарчмыг ойлгож дүгнэлтийг нь зөв хэрэглэх шаардлагатай. Зарим улс оронд шүүгчдэд зориулсан хиймэл оюун ухааны сургалтууд зохион байгуулагдаж, өөрсдийн туслахуудаасаа гадна алгоритмыг “дасган сургах” дадлага хийж эхэлжээ. Шүүгчид хиймэл оюун ашиглах явцад гарч болзошгүй алдаа, ялгавартай хандлага, мэдээлэл алдагдах зэрэг эрсдэлийг байнга санаж, шүүн таслах ажиллагаанд сөргөөр нөлөөлж болох аливаа тохиолдлыг таслан зогсоох үүрэг хүлээдэг. Жишээлбэл, 2023 онд АНУ-ын зарим шүүгч хэрэг хянан шийдвэрлэх явцад талуудын гаргаж буй баримт бичиг, нотлох байдлыг харахад *хиймэл оюуны тусламжтай бэлдсэн шинж* анзаарагдвал, тухайн өмгөөлөгчөөс нэмэлт тайлбар шаардах, эсвэл шийтгэл оногдуулах арга хэмжээ авсан талаар дээр дурдсан.²² Хиймэл оюуныг *хяналттайгаар зөв ашиглах болон буруугаар хэрэглэвэл засаж залруулах* нь бүхэлдээ шүүгчийн үүрэг гэдгийг харуулж байна.

Шүүхийн байгууллагын түвшинд, хиймэл оюуныг нэвтрүүлэхдээ байгууллага дотроо тодорхой бодлого, журамтай байх нь чухал зарчим болж байна. Ихэнх улс оронд шүүхийн тамгын газар, захиргаанаас хиймэл оюун ухаан ашиглахтай холбоотой бодлого, үйл ажиллагааны заавар гаргаж, шүүхийн мэдээллийн технологийн хэлтсүүдэд мөрдүүлж эхэлсэн. Эдгээрт нийтийн ашиг сонирхолд харшлахгүй байх, шүүхийн ил тод байдлыг нэмэгдүүлэхэд хувь нэмэртэй байх, шийдвэр гаргалтад хүний оролцоог хангасан технологи ашиглах, мэдээллийн аюулгүй байдлыг хангах тусгай арга хэмжээ

²⁰ Vytאות Mizaras, Yogesh K. Dwivedi, Brian D. Earp, Mark Fenwick, Paul Jurcys, Souichirou Kozuka, Sebastian Porsdam Mann, *supra* note 13

²¹ *Guidelines for Judicial Officers: Responsible Use of Artificial Intelligence*, <https://www.americanbar.org/groups/judicial/resources/judges-journal/2025-spring/guidelines-judicial-officers-responsible-use-artificial-intelligence/>

²² Reuters, *supra* note 9

авах зэрэг зарчмууд багтдаг. Жишээлбэл, Европын орнуудын шүүхүүд олон нийтийн итгэлийг алдахгүйн тулд хиймэл оюун ухааны хэрэглээний талаар тайлан мэдээллийг тогтмол гаргаж, ямар төрлийн хэрэгт ямар хиймэл оюун ухааны хэрэгсэл ашиглаж буйг олон нийтэд мэдээлдэг болж байна. Францын Шүүхийн ерөнхий зөвлөл 2022 оноос шүүхийн шийдвэрийн өгөгдлийг боловсруулах, шийдвэр гаргалтад дэмжлэг үзүүлэх хиймэл оюун ухааны хэрэгслийг зөвхөн шүүхийн дотоод сүлжээнд ажиллуулах, гаднын шууд хяналтгүй байх журам мөрдүүлж эхэлсэн нь шүүхийн хараат бус байдлыг хамгаалах зорилготой. Үүнтэй адил Герман болон Сингапурын шүүхийн захиргаанд хиймэл оюун ухаан хэрэглэх зөвшөөрөгдсөн болон хориглосон хүрээг тогтоосон. Тухайлбал шүүхийн дотоод хэрэг хуваарилалт, шүүн таслах ажиллагааны явцад ямар нэг шийдвэрийг бүрэн автоматаар гаргахыг хориглодог. Шүүхийн байгууллагын хувьд чухал үүргүүдийн нэг нь шаардлагатай хүний нөөц, сургалтыг тасралтгүй зохион байгуулах явдал юм. Хиймэл оюун ухаан нэвтэрснээр зарим төрлийн албан хаагчдын ажил өөрчлөгдөж (жишээ нь, мэдээллийн технологийн мэргэжилтэн, өгөгдөл шинжээч гэх мэт шинэ орон тоо нэмэгдэх), заримынх нь ур чадварт шинэтгэл хэрэгтэй болж байна. Иймээс шүүхийн захиргааны байгууллага бүр шүүгч, шүүхийн ажилтнууддаа зориулсан хиймэл оюун ухаан ба ёс зүйн асуудал сэдэвт сургалтыг тогтмол зохион байгуулж, мөн шүүхийн мэдээллийн системийн аюулгүй байдал, доголдлыг байнга хянан, хөндлөнгийн аудит хийлгэх нь орчин үеийн шүүхийн засаглалын салшгүй хэсэг болж байна. Үүнийг олон улсын түвшинд ч зөвлөж, OECD-ээс 2023 онд гаргасан “Хуулийн хэрэгжилт ба хиймэл оюун ухаан” тайланд шүүхүүд хиймэл оюун ухааны нөлөөгөөр үүсэх шинэ төрлийн эрсдэлийг тогтмол үнэлж, хяналт шинжилгээ хийх нэгжтэй байх хэрэгтэйг дурдсан байдаг.²³

Шүүхийн оролцогч талууд (өмгөөлөгч, прокурор, иргэд)–ын хувьд ч хиймэл оюуны эрин үеийн шинэ үүрэг, соёл төлөвшиж байна. Өмгөөлөгчид хэргийг хянан шийдвэрлэх явцад хиймэл оюуныг ашиглах нь өргөн үзэгдэл болж байна. Жишээлбэл, ижил төстэй хэргийн шийдвэрийн хайлт хийх, шүүхийн журмыг тайлбарлах, зарим баримт бичгийг боловсруулахад *ChatGPT* мэт хэлний загваруудыг ашиглах нь нэмэгджээ. Гэвч энэ хэрэглээ нь нөгөө талдаа өмгөөлөгчдөд *илүү анхаарал, хянамгай байдал* шаардаж байна. *Mata v. Avianca, Inc.* хэргийн нэгэн адилаар шүүхэд худал, зохиомол агуулга бүхий баримт бичиг гаргаж болзошгүй эрсдэл бодитоор илэрч, үүнээс үүдэн технологийн мэдлэгтэй байх, хиймэл оюун ухааны гаргалгааг баталгаажуулах нь өмгөөлөгчдийн мэргэжлийн үүргийн нэг хэсэг болохыг шүүх онцгойлон сануулсан байна. Тухайлбал, Нью-Йорк мужийн Дээд шүүх 2023 оны шийдвэртээ дээрх өмгөөлөгчдийн үйлдлийг мэргэжлийн хайхрамжгүй байдал гэж үзээд, технологийн хэрэгслээс илэрсэн алдааг мэдсээр байж залруулаагүй нь ноцтой зөрчил болохыг дурдсан байдаг.²⁴ Үүнээс гадна АНУ, Европын зарим улсад Өмгөөлөгчдийн холбоо болон Прокурорын байгууллагууд өөрсдийн ёс зүйн дүрэмд нэмэлт өөрчлөлт оруулж, “Хуулийн технологийн мэдлэг, зохистой хэрэглээ нь хуульчийн үндсэн чадварын хэсэг

²³ Thomson Reuters Institute, *supra* note 14

²⁴ Reuters, *supra* note 9

мөн” гэсэн заалтыг нэмж байна. Өөрөөр хэлбэл, орчин цагийн хуульч нь зөвхөн хууль мэдэхээс гадна технологийн боломж, эрсдэлийг ойлгодог, үйлчлүүлэгчийнхээ мэдээллийг аливаа хиймэл оюун ухаанд оруулахдаа нууцлалыг хэрхэн хамгаалах, үүсэх хариуцлагын асуудлыг урьдчилан тооцдог байхыг шаардах болжээ. Зарим улсад хиймэл оюуныг ашиглан бэлтгэсэн баримт бичгийг шүүхэд гаргахдаа заавал тэмдэглэх журмыг ч нэвтрүүлж эхэлсэн талаар дээр өгүүлсэн.

Иргэдийн зүгээс авч үзвэл, хиймэл оюун ухаан хөгжсөнөөр шүүхэд хандах боломж, хүртээмж нэмэгдэх эерэг хандлагатай байна. Өмнө нь хууль зүйн мэдлэггүй, өмгөөлөгч авах төлбөрийн чадамж муутай иргэд шүүхэд хандахад бэрхшээлтэй байсан бол одоо шүүх, засгийн газрын байгууллагуудын гаргасан хууль зүйн чатбот, зөвлөгөө өгөх автомат системүүд тэдэнд бага зардлаар эрхээ хамгаалах боломж өгч байна. Тухайлбал, Их Британи, Австрали, Сингапур зэрэг улсад замын хөдөлгөөний торгууль, хэрэглэгчийн эрхийн маргаан зэрэг жижиг хэргийн маргаанд иргэдэд тусалдаг автомат зөвлөх программ (DoNotPay зэрэг) бий болсон. Гэвч ийм төрлийн “робот өмгөөлөгч” нар хуулиар зөвшөөрөгдөөгүй үйл ажиллагаа явуулсан тохиолдол ч гарчээ. 2023 оны эхээр АНУ-ын старт-ап компани хиймэл оюун ухааны программаар шүүх хуралдаан дээр өмгөөлүүлэхээр төлөвлөж байгаагаа зарлахад хууль зүйн зохицуулалтын дагуу тухайн программ нь *өөрөө өөрийгөө төлөөлөх эрхтэй этгээд биш*, хуульчийн тусгай зөвшөөрөлгүй байж хуульчийн мэргэжлийн үйл ажиллагаа эрхлэх *гэж оролдсон* гэж үзэн хориглосон юм. Үүнээс үзвэл иргэд хиймэл оюун ухаан ашиглан шүүхэд хандах нь зохистой ч, хуульчийн дэмжлэгийг орлох хэмжээнд ашиглах нь хууль зөрчих эрсдэлтэй хэвээр байна.

Нийтийн ашиг сонирхлын хүрээнд хиймэл оюуныг шүүхэд хэрэглэх нь *олон нийтийн шүүхэд итгэх итгэл* болон *шүүхийн шийдвэрийн хууль ёсны байдалд* нөлөөлөх өргөн сэдэв юм. Канад, АНУ-ын эрдэмтэд 2025 онд хамтран олон нийтийн дунд санал асуулга явуулахад, ихэнх хүмүүс зөвхөн хүн шүүгчийн өөрийнх нь мэдлэгээр гаргасан шийдвэрт хиймэл оюун ухааны тусламжтай гаргаснаас илүү итгэлтэй, шударга гэж хүлээн авч байна гэсэн үр дүн гарчээ. Ялангуяа эрүүгийн хэрэг (барьцаат суллах, ялын хэмжээ тогтоох гэх мэт) дээр шүүгч алгоритмын зөвлөмжид найдах нь шүүхийн шийдвэрийг улам ойлгомжгүй, хүнлэг бус болгоно гэж болгоомжилдог бүлэг хүмүүс байгаа нь тогтоогдсон байна. Тиймээс шүүх засаглал өөрийн шийдвэрийн тухай олон нийтэд таниулахдаа *хиймэл оюуны оролцоог бодитоор нь мэдээлж байх, ил тод байдлыг бүрэн хангах* нь эрх зүйн төдийгүй нийгмийн итгэлийн зарчим болоод байна.²⁵

4. Дүгнэлт

Дээрхээс дүгнэхэд, шүүхийн үйл ажиллагаанд хиймэл оюуныг ашиглах явц 2015-2025 оны хооронд хууль зүй, ёс зүйн түвшинд ихээхэн анхаарал татаж, олон улсын, үндэсний хэмжээний зохицуулалт, санаачилгыг өрнүүлжээ. Хиймэл оюун ухаан нь

²⁵ *Public Perceptions of Judges’ Use of AI Tools in Courtroom Decision-Making: An Examination of Legitimacy, Fairness, Trust, and Procedural Justice*, <https://www.mdpi.com/2076-328X/15/4/476>

шүүхийн ажлыг дэмжин хөнгөвчлөх ач холбогдолтой боловч хүний гаргах ёстой эцсийн шийдвэр, шударга шүүхийн зарчмыг орлож болохгүй гэсэн эрх зүйн үзэл санаа бат бөх зогсож байна.

Өнөөдрийн байдлаар дэлхийн улс орнууд дараах зохицуулалт, судалгааны ажлуудыг системтэйгээр ангилан хөгжүүлж байна:

- **Ёс зүй, хүний эрхийн хүрээний баримт бичгүүд:** Жишээлбэл, Европын зөвлөлийн (СЕРЕJ) 2018 оны Ёс зүйн Хартад шүүхэд хиймэл оюун ухаан хэрэглэхэд баримтлах үндсэн зарчмуудыг (үндсэн эрх, ялгаварлалгүй байдал, шударга байдал гэх мэт) тодорхойлсон. UNESCO-ийн 2021 оны Хиймэл оюуны ёс зүйн зөвлөмж, OECD-ийн 2019 оны хиймэл оюун ухааны зарчмууд нь ерөнхий боловч хүний эрхэд суурилсан хандлагыг түгээж байна.
- **Эрх зүйн зохицуулалтын баримт бичгүүд:** Үүнд олон улсын гэрээ, хууль тогтоомжууд багтана. Европын Холбооны Хиймэл оюуны тухай хууль нь салбар дундын зохицуулалт ч шүүхийг шууд хамарч, шүүхийн хиймэл оюун ухааны системийг “өндөр эрсдэлтэй” бүлэгт ангилж, хяналт, тайлбар, хүний оролцоог хуульчилж буй томоохон акт юм.²⁶ Мөн GDPR зэрэг зохицуулалтаар иргэдийг автомат шийдвэр гаргалтаас хамгаалах хэм хэмжээ тогтоосноор шүүхийн үйл ажиллагаанд шууд нөлөө үзүүлж байна. Үндэсний түвшинд АНУ-д тусгай AI хууль байхгүй ч шүүхийн шийдвэр, муж улсын жижиг актаар зарим хэм хэмжээг тогтоосон; Япон Улс хиймэл оюуны хүрээнд уян хатан зохицуулалт мөрдөж эхэлсэн; харин Хятад, Сингапур зэрэгт төрийн бодлого, стратегиудаар зохицуулж байна.
- **Шүүх, хууль зүйн байгууллагын гаргасан удирдамж, дүрэм:** Энэ ангилалд шүүхийн дотоод журам, шүүгчдэд болон хуульчдад зориулсан зөвлөмжүүд орно. Жишээлбэл, Америкийн шүүгчдийн боловсруулсан 2025 оны удирдамжид “Хиймэл оюуныг ашиглахдаа шүүгч хүн өөрийн мэргэжлийн шүүлтээ хадгалах (орхигдуулж болохгүй гэсэн агуулгаар) ёстой” гэж заасан.²⁷ Мөн Солонгосын шүүхийн зөвлөмж (2024), Австралийн шүүхийн практикийн заавар (2023) зэрэг нь тус тусдаа улс орны нөхцөлд тохируулан бүтээгч (generative) хиймэл оюуныг хэрэглэхдээ нотлох баримтыг баталгаажуулах, хиймэл оюуны санал нь зөвлөгөө өгөх хэмжээнээс хэтрэхгүй гэх мэт дүрмийг тогтоож байна.²⁸
- **Академик судалгааны бүтээлүүд, онолын судалгаа:** Олон судлаачид шүүх ба хиймэл оюун ухаан сэдвээр хүний эрх, процессын эрх зүй, технологи-эрх зүйн огтлолцлыг шинжилсэн байна. Жишээлбэл, 2025 онд хэвлэгдсэн системчилсэн өгүүлэлд хиймэл оюун ухаан шүүхийн “шударга шүүхээр шүүлгэх эрх”-д хэрхэн

²⁶ Recital 61, *supra* note 3

²⁷ *Guidelines for Judicial Officers: Responsible Use of Artificial Intelligence*, <https://www.americanbar.org/groups/judicial/resources/judges-journal/2025-spring/guidelines-judicial-officers-responsible-use-artificial-intelligence/>

²⁸ Thomson Reuters Institute, *supra* note 14

нөлөөлөхийг европын зохицуулалтын хүрээнд задлан үзэж, тэр дундаа талуудын үг хэлэх эрх (танхимд ярих, хэлэх боломж), шүүгчийн хараат бус байдал, шүүхийн шийдвэрийн ил тод байдал зэрэг бүрэлдэхүүн хэсгүүдэд хиймэл оюуны үзүүлэх эерэг сөрөг үр дагаврыг судалжээ.²⁹ Мөн зарим бүтээлд “шүүгч-хиймэл оюун хоёрын хамтын ажиллагаа” (judge-in-the-loop) загварыг хөгжүүлэх нь зөв хэмээн нотолж, хиймэл оюун ухаан нь шүүгчийн алдаа гаргах магадлалыг бууруулах, хэрэг хялбаршуулах ч нөгөө талдаа нийтийн итгэл, хууль ёсны байдлыг нь бууруулахгүй байх нөхцөлийг (алгоритмын тайлбарлагдах байдал гэх мэт) хангуулах ёстойг онцолдог.³⁰ Энэ ангилалд мөн хиймэл оюун ухааны хэрэглээний талаарх социологийн судалгаанууд багтана. Дээр дурдсан олон нийтийн итгэлийн санал асуулга, жишээлбэл хүмүүс хиймэл оюун ухаан ашигласан шүүгчийн шийдвэрт бага итгэдэг нь тогтоогдсон судалгаа нь шүүх эрх мэдэлд чухал дохио өгч байна.

- **Практик туршлага:** Зарим судалгаанд тодорхой орнуудын кейс, төслүүдийг харьцуулсан байна. Жишээлбэл, Аргентин улсын Прометеа гэх хиймэл оюун ухааны систем (2017–2022) богино хугацаанд олон хэрэг шийдвэрлэхэд тусалсан ч цар хүрээг нь тэлэхэд бэрхшээл тулгарсан, харин 2024 онд тус улс ChatGPT-г захиргааны хэргийн шийдвэрийн төсөл бичихэд туршиж, 10 минутад шийдвэрийн төсөл гаргуулж байгаа зэрэг туршлагыг OECD-ийн тайланд тэмдэглэжээ.³¹ Мөн Перу Улсын шүүх гэр бүлийн хүчирхийллээс хамгаалах түргэн арга хэмжээ авах ажиллагаанд хиймэл оюуныг нэвтрүүлж, хэдхэн минутад хамгаалах шийдвэрийн төсөл бэлэн болгодог Amauta Pro системийг 2023 онд туршсан нь амжилттай болсон гэх мэт практик кейсүүд бий.³² Ийм туршлагын баримтууд нь цаашид шүүхэд хиймэл оюун ухаан хэрэглэх бодлого, эрх зүйн зохицуулалтыг сайжруулахад чухал хөрс суурь болж байна.

Эдгээр нь шүүхийн хиймэл оюун ухааны хэрэглээний судалгааг системтэйгээр ангилан дүгнэхэд хэрэгтэй бөгөөд цаашид шинэ технологийг шүүхийн үйл ажиллагаанд нэвтрүүлэхдээ хууль дээдлэх ёс, шударга шүүхээр шүүлгэх эрхийг хадгалахын зэрэгцээ үр ашиг, хүртээмжийг нэмэгдүүлэх хосолсон зорилгыг хэрхэн тэнцвэржүүлэх вэ гэдэгт чиглэсэн олон талт шинжилгээ шаардлагатайг харуулж байна. Энэ системчилсэн судалгаагаар улс орнуудын туршлага, академик үнэлгээ, бодлогын баримт бичгүүдийг авч үзсэн ба “хиймэл оюун нь шүүхэд ашигтай ч ёс зүйн хяналттай, хүний хяналт дор байх ёстой” гэсэн зарчимд судлаачид, хууль тогтоогчид, шүүхийнхэн өргөн хүрээнд санал нэгтэй байна хэмээн дүгнэж болох юм. Цаашид ч энэхүү зарчмыг олон улс оронд

²⁹ AI-driven civil litigation: Navigating the right to a fair trial | AVESIS, <https://avesis.ogu.edu.tr/yayin/70e3a163-ac4c-4c60-8428-0b258590f091/ai-driven-civil-litigation-navigating-the-right-to-a-fair-trial>

³⁰ Vytautas Mizaras, Yogesh K. Dwivedi, Brian D. Earp, Mark Fenwick, Paul Jurcys, Souichirou Kozuka, Sebastian Porsdam Mann, *supra* note 13

³¹ AI in justice administration and access to justice: Governing with Artificial Intelligence | OECD, https://www.oecd.org/en/publications/2025/06/governing-with-artificial-intelligence_398fa287/full-report/ai-in-justice-administration-and-access-to-justice_f0cbe651.html

³² OECD, *supra* note 61

хуульчлан бататгаж, хэрэгжилтийг хангах нь шүүхийн шинэтгэлийн зайлшгүй хэсэг болно.

5. Эх сурвалж

- 1. American Bar Association. “Guidelines for Judicial Officers: Responsible Use of Artificial Intelligence.” *Judges’ Journal*, Spring 2025. <https://www.americanbar.org/groups/judicial/resources/judges-journal/2025-spring/guidelines-judicial-officers-responsible-use-artificial-intelligence/>
- 2. Council of Europe, European Commission for the Efficiency of Justice (CEPEJ). *European Ethical Charter on the Use of Artificial Intelligence (AI) in Judicial Systems and Their Environment*. Strasbourg, 2018. <https://www.coe.int/en/web/cepej/cepej-european-ethical-charter-on-the-use-of-artificial-intelligence-ai-in-judicial-systems-and-their-environment>
- 3. European Union. Regulation (EU) 2016/679 of the European Parliament and of the Council of 27 April 2016 (General Data Protection Regulation). *Official Journal of the European Union* L 119 (2016). <https://eur-lex.europa.eu/eli/reg/2016/679/oj/eng>
- 4. European Union. Regulation (EU) 2024/1689 Laying Down Harmonised Rules on Artificial Intelligence (Artificial Intelligence Act). *Official Journal of the European Union* (2024). <https://eur-lex.europa.eu/legal-content/EN/TXT/?uri=CELEX:32024R1689>
- 5. European Union. *Artificial Intelligence Act, Recital 61: High-Risk AI Systems in the Administration of Justice*. <https://ai-act-law.eu/recital/61/>
- 6. Harvard Law Review. “State v. Loomis.” *Harvard Law Review* 130 (2017). <https://harvardlawreview.org/print/vol-130/state-v-loomis/>
- 7. IBM. “Judicial Systems Are Turning to AI to Help Manage Vast Quantities of Data and Expedite Case Resolution.” *IBM Case Studies Blog*. <https://www.ibm.com/case-studies/blog/judicial-systems-are-turning-to-ai-to-help-manage-its-vast-quantities-of-data-and-expedite-case-resolution>
-
- 8. Mizaras, Vytautas, Yogesh K. Dwivedi, Brian D. Earp, Mark Fenwick, Paul Jurcys, Souichirou Kozuka, and Sebastian Porsdam Mann. “AI Judges in Courts of the Future and the Right to a Fair Trial in the ECHR.” *SSRN Working Paper* (2024). https://papers.ssrn.com/sol3/papers.cfm?abstract_id=5189606
- 9. National Center for State Courts. *Principles and Practices for AI Use in Courts* <https://www.ncsc.org/resources-courts/principles-practices-ai-use-courts>
- 10. Organisation for Economic Co-operation and Development (OECD). *AI in Justice Administration and Access to Justice: Governing with Artificial Intelligence*. Paris: OECD Publishing, 2025. https://www.oecd.org/en/publications/2025/06/governing-with-artificial-intelligence_398fa287/full-report/ai-in-justice-administration-and-access-to-justice_f0cbe651.html
- 11. Reuters. “New York Lawyers Sanctioned for Using Fake ChatGPT Cases in Legal Brief.” June 22, 2023. <https://www.reuters.com/legal/new-york-lawyers-sanctioned-using-fake-chatgpt-cases-legal-brief-2023-06-22/>

- 12. Thomson Reuters Institute. “How Asia Pacific Region Courts Are Managing AI Adoption.” <https://www.thomsonreuters.com/en-us/posts/ai-in-courts/asia-pacific-courts-ai/>
- 13. Uğur, Ayşe. “AI-Driven Civil Litigation: Navigating the Right to a Fair Trial.” *AVESIS Academic Publication Database*. <https://avesis.ogu.edu.tr/yayin/70e3a163-ac4c-4c60-8428-0b258590f091/ai-driven-civil-litigation-navigating-the-right-to-a-fair-trial>
- 14. Zhang, Y., et al. “Public Perceptions of Judges’ Use of AI Tools in Courtroom Decision-Making: An Examination of Legitimacy, Fairness, Trust, and Procedural Justice.” *Behavioral Sciences* 15, no. 4 (2025): 476. <https://www.mdpi.com/2076-328X/15/4/476>

---oOo---